



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар дахин худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан 2 ширхэг автомашины 3 дахь удаагийн нээлттэй дуудлагын худалдааг дахин зохион байгуулсугай.

2.Автомашины худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

3.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Содномжамц, Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Т.Мөнхсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

3.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;


3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА




Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002023

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
 226 дугаар тогтоолын хавсралт



ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИН

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар	Үйлдвэр-лэгдсэн /Ашиглал-тад орсон огноо	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Үлдэгдэл үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2016 оны 254 дүгээр тогтоолоор тогтоосон доод үнэ (төгрөг)	Худалдах доод үнэ 50% бууруулж тогтоосон (төгрөг)
1	Истана микро автобус, 64-65 УБН, түргэн тусламжийн, хөдөлгүүр-22283, арал-KRDFBGB811P32358	2007/2007	165926	37 070 000,00	-	6 500 000,00	3 250 000,00
2	Foton, 01-30 УНГ, түргэн тусламжийн, хөдөлгүүр-908488, арал-LVCB1DWA79BC101968	2009/2009	18270	35 961 250,00	-	6 500 000,00	3 250 000,00
	Нийт дүн	-	-	73,031,250.00 (далан гурван сая гучин нэгэн мянга хоёр зуун тавин)	-	13,000,000.00 (арван гурван сая)	6,500,000.00 (зургаан сая таван зуун мянган)